

## ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2026 оны I улирлын түүвэр судалгааны тайлан)

### Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2026 оны 2-р сарын 16-28-ны өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 24 шинжээчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

#### Шинжээчид:

##### 2026 оны I улиралд

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 7.9%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 5.5%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.0%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.2% байна гэж төсөөлсөн байна.

##### 2026 оны IV улиралд

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 7.9%,
- Эдийн засгийн өсөлт 5.8%,
- Бодлогын хүү бага зэрэг буурч 11.3%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.2% байна гэж төсөөлсөн байна.

#### Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2026 он 1 сар	2026 он I улирал	2026 оны IV улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, %/	7.5%	7.9%	7.9%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	6.8%*	5.5%	5.8%
Төв банкны бодлогын хүү /%/	12.0%	12.0%	11.3%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.1%	17.2%	17.2%

\* 2025 оны жилийн эцэст


*Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын төсөөллийн нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.*

© МОНГОЛБАНК, 2026

## I. Инфляц


Инфляц 2025 оны IV улиралд улсын<sup>1</sup> хэмжээнд 7.5% болж буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн төсөөллийн дундаж 9.5%-аас 2.0 нэгж хувиар доогуур гарлаа. Шинжээчид 2026 оны I улиралд улсын инфляц 7.9%, оны эцэст мөн 7.9%-д хүрнэ гэж төсөөлж байна (Зураг 1).

**Зураг 1. Инфляцын төсөөлөл**



Шинжээчдийн инфляцын төсөөллийг тархалтаар нь авч үзвэл 2026 оны I улиралд инфляц 8.0-8.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 32.4%, 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал 31.3%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2026 оны I улиралд инфляц 9.0-9.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.6% гэж төсөөлж байжээ (Зураг 2).


**Зураг 2. Инфляцын төсөөллийн тархалт /2026 оны I улирал/**



<sup>1</sup> 2025 оны III улирлаас улсын инфляцыг бодлогын шийдвэрт ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор тус түүвэр судалгааны асуулгыг мөн улсын инфляц болгон өөрчилсөн болно.


Энэ удаагийн инфляцын төсөөллийн үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын төсөөлөлтэй харьцуулахад буурсан бөгөөд цаашид энэ түвшинд тогтворжих хандлагатай байна. Шинжээчид 2026 оны I улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 9.4% гэж төсөөлж байсан бол энэ удаагийн судалгаагаар 7.9% гэж төсөөлжээ (Зураг 3).

**Зураг 3. Инфляцын өмнөх төсөөллүүдийн харьцуулалт**



Инфляцын төсөөллийг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу тус бүр 7.9, 8.2% байна (Зураг 4).


**Зураг 4. Ирэх улирлын инфляцын төсөөлөл /2026 оны I улирал/**



## II. Эдийн засгийн өсөлт


2025 оны жилийн эцэст эдийн засгийн өсөлт 6.8% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн төсөөллийн дундаж 5.6%-аас 1.2 нэгж хувиар өндөр гарчээ. Шинжээчид эдийн засгийн өсөлт 2026 оны I улиралд 5.5%, 2026 оны эцэст 5.8% гэж төсөөлж байна (Зураг 5).

**Зураг 5. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл**




Эдийн засгийн өсөлтийн өсөлтийг тархалтаар нь авч үзвэл 2026 оны I улиралд 4.0-4.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 23.0%, 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал 21.1%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2026 оны I улиралд өсөлт 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.6% гэж төсөөлж байжээ (Зураг 6).

**Зураг 6. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тархалт /2026 оны I улирал/**




Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх түүвэр судалгаануудын төсөөлөлтэй харьцуулахад нэлээд нэмэгдсэн хэдий ч цаашид одоогийн түвшнээс бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2026 оны I улирлын эдийн засгийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 5.5% байна гэж төсөөлж байсан бол энэ удаагийн судалгаагаар мөн 5.5% гэж төсөөлж, төсөөлөлд өөрчлөлт ороогүй байна (Зураг 7).

**Зураг 7. Эдийн засгийн өсөлтийн өмнөх төсөөллүүдийн харьцуулалт**



Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг тоон хариултын медиан болон тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 5.2-5.6% орчимд байна (Зураг 8).


**Зураг 8. Ирэх улирлын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл /2026 оны I улирал/**



### Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2026 оны I улиралд дунджаар 12.0% байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 2026 оны эцэст 11.3% байна гэж таамаглажээ (Зураг 9).

**Зураг 9. Бодлогын хүүний хүлээлт**




Бодлогын хүүний хүлээлтийг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2026 оны I улиралд бодлогын хүү 12.0% байна гэсэн хүлээлттэй байна (Зураг 10).

**Зураг 10. Бодлогын хүүний хүлээлтийн тархалт /2026 оны I улирал, хариултын тоогоор/**



Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2026 оны I улирлын бодлогын хүүг 11.8% байна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.0% байна гэж таамаглажээ (Зураг 11).


**Зураг 11. Бодлогын хүүний өмнөх хүлээлтүүдийн харьцуулалт**



### IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2026 оны I улиралд дунджаар 17.2%, хамгийн ихдээ 17.7%, хамгийн багадаа 16.5%-тай байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид зээлийн хүү өнөөгийн түвшинд хэвээр 17.2% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

**Зураг 12. Зээлийн хүүний хүлээлт**




Зээлийн хүүний хүлээлтийг тархалтаар нь харвал 2026 оны I улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 17.2-17.4% байна гэсэн хүлээлт давамгайлж байна (Зураг 13).

**Зураг 13. Зээлийн хүүний хүлээлтийн тархалт /2026 оны I улирал, хариултын тоогоор/**



Сүүлийн улирлуудад шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү харьцангуй тогтвортой байгаатай холбоотойгоор шинжээчдийн хүлээлт мөн тогтворжиж байна. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2026 оны I улиралд зээлийн хүүг 17.3% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 17.2% гарна гэж үзсэн байна (Зураг 14).

**Зураг 14. Зээлийн хүүний өмнөх хүлээлтүүдийн харьцуулалт**



--- o o o ---